

2. Үнэт цаас эзэмшигчийн эрх:

МХБ-ээр дамжуулан энгийн хувьцааг худалдан авч өмчилсөн байгууллага, иргэн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 1) Хувьцаагаа хоёрдогч зах зээл дээр худалдах;*
- 2) Хувьцаагаа барьцаалах, бэлэглэх;*
- 3) Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмисэн этгээд компанийн хувь нийлүүлэгч болно.*
- 4) Компанийн хувь нийлүүлэгчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэх өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.*
- 5) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах.*
- 6) Компанийг татан буулгах үед “Компанийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.*
- 7) Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.*

- 8) Хувь нийлүүлэгчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- a. Нийтлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
 - b. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
 - c. Компанийн хувь нийлүүлэгчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан;
 - d. Нэг хувь нийлүүлэгч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
 - e. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувь нийлүүлэгч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
 - f. Хувь нийлүүлэгч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.